



БАЯНХОНГОР АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

ЗӨВЛӨМЖ

2025 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 03.

Номгон

Г Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын
санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах тухай

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдөр баталсан 07/03 дугаар удирдамжийн дагуу Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2023, 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Б.Бат-Эрдэнэ, дотоод аудитор Д.Цолмон нар 2025 оны 02 дугаар сарын 17-ноос 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийг хүртлэх хугацаанд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчилд дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Эрх зүйн чадамжтай шийдвэр гаргахдаа тухай шийдвэрийн утга санаанд нийцсэн хууль тогтоомж журмыг үндэслэн гарган Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.6-т "Хууль бус захиргааны акт гэж эрх зүйн зөрчилтэй захиргааны актыг ойлгоно", 47 дугаар зүйлийн 47.1.1-т "утга агуулгын илэрхий алдаатай", 47.1.6-т "захиргааны акт гаргах эрх зүйн үндэслэл байгаагүй" гэсэн заалтыг хэрэгжүүлэх.

2. Мэдээллийн ил тод байдлын хангаж, шилэн дансны портал сайтад мэдээллийг хугацаанд нь иж бүрэн үнэн зөв, хугацаандаа мэдээлж Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

3. Ажилтан албан хаагчдын амралтын хуваарийг нэгдүгээр улиралд багтаан гаргаж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалаар баталсан "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 1.2-т "Ажил олгогч нь тухайн ажлын жилийн ээлжийн амралтын хуваарийг ажилтын саналыг үндэслэн ажил, үйлчилгээ, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байдлаар зохион байгуулж, жил бүрийн нэгдүгээр улиралд батална" гэсэн заалтыг хэрэгжүүлэх.

4. Байгууллагын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам, жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулан байгууллагын даргаар баталгаажуулан дотоод хяналт шалгалтыг улирал дутам зохион байгуулж Засгийн Газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-н өдөр баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд

642512001

дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 1.5-т Энэхүү журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд "дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ыг тухай байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө", 2.3-т "Дотоод хяналт шалгалтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг бүрэн хамарсан байвал зохино", 3.7.1-т "зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах", 4.1.4-т "хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд тавих хяналт шалгалт", 4.1.5-т "өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй.

5. Ээлжийн амралтыг цалинтай давхардуулан олгохгүй байх, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-т "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно" гэсэн заалтыг мөрдөх.

6. Албан хаагч нарт илүү цагийг тооцож олгохдоо анхан шатны баримт болох ажлын цаг ашиглалтын бүртгэлийг нэг бүрчлэн хөтөлж, нэмэгдэл цагийн хөлс олгох хуудсаар баталгаажуулан олгож цагийн бүртгэлийг сайжруулах.

7. Байгууллагын даргын 1,3 дугаар улирлын үр дүнгийн урамшууллыг олгохдоо, байгууллагын Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн, аймгийн Засаг даргаар шийдвэр гаргуулан ажиллаж Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 3.3-т "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага нь эрүүл мэндийн ажилтанд мөнгөн урамшуулал олгохдоо энэ журмын 3.4-т заасан шалгуур үзүүлэлтийг баримтлан ажлын үр дүн, гүйцэтгэлийг дүгнэж, тухайн жилийн төсөвт уг урамшуулалд зориулан батлагдсан хөрөнгийн дүнд багтаан энэ журмын 3.10, 3.12-т заасан шийдвэрийг үндэслэн олгоно", 3.12-т "Эрүүл мэндийн байгууллагын даргын ажлын үр дүнг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар болон тухайн албан тушаалтныг томилсон эрх бүхий албан тушаалтан дүгнэж, шийдвэр гаргана" гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

Хяналт шалгалтаар тогтоосон төлбөрийн актыг хугацаанд нь барагдуулан, албан шаардлагыг хэрэгжүүлж, зөвлөмжийн дагуу төлөвлөгөө боловсруулан илэрсэн зөрчил дутагдлыг дахин давтан гаргахгүй байх тал дээр анхаарч хариуг 2025 оны 08 дугаар сарын 30-ны дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт

албан бичгээр, нотлох баримтын хамт ирүүлэхийг Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Одонтунгалаг, Хэлтэс албаны дарга нарт, Ерөнхий нягтлан бодогч П.Мөнх-Эрдэнэ, бусад албан хаагч нарт хариуцуулав.

Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаагүй зөвлөмжийг биелүүлж хариу ирүүлээгүй тохиолдолд Дотоод аудитын дүрэмд заасан арга хэмжээ авч ажиллахыг анхааруулав.

ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА  Я.ЖАРГАЛЦЭЦЭГ

ЗӨВЛӨМЖ БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН УЛСЫН
АХЛАХ БАЙЦААГЧ  Б.БАТ-ЭРДЭНЭ

ДОТООД АУДИТОР  Д.ЦОЛМОН

ТАНИЛЦСАН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Т.ОДОНТУНГАЛАГ

ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗРЫН ДАРГА

Н.ЭНХЖАРГАЛ

ЕРӨНХИЙ НЯГТЛАН
БОДОГЧ

 П.МӨНХ-ЭРДЭНЭ